

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 11 дүгээр  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан үндсэн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль санаачилна.” гэснийг “Ерөнхийлөгч энэ хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3-т зааснаас бусад асуудлаар хууль санаачилна. Ерөнхийлөгч хууль санаачлахдаа Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтална.” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл” гэснийг “хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.11.1 дэх заалтын “эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл;” гэснийг хассугай.

Гарын үсэг